

## Товч танилцуулга

Монгол улсын баруун 3 аймгийг найдвартай цахилгааны эх үүсвэрээр хангах асуудал нь Монгол улсын Засгийн Газрын сүүлийн хэдэн арван жилийн төдийгүй цаашид ч анхаарал татсан асуудлын нэг болж байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд судалгааны олон ажил хийгдэж хэд хэдэн хувилбар гарсны нэг нь Ховд аймгийн Дөргөн сумын нутагт Чоно-харайх голын хавцлыг боож УЦС барих төсөл болно. Энэхүү төслийн гол зорилго нь баруун бүсийн ард иргэдийг цахилгааны найдвартай нэмэлт эх үүсвэрээр хангаж, ОХУ-аас импортоор авдаг цахилгаанаас хамаарах байдлыг бууруулахад чиглэжээ. Чоно-харайх гол нь Хар ус нуурын Байгалийн цогцолборт газар (ХУНБЦГ)-ын орчны бүсэд төдийгүй Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (ДБХС)-гаас тодорхойлсон зайлшгүй хамгаалах шаардлагатай 200 эко бүс нутгийн нэг болох Алтай-Саяаны бүс нутагт оршино.

Энэхүү УЦС-ын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон нийгэм-эдийн засаг, байгаль орчин, хууль зүйн холбогдол бүхий олон асуудлууд хөндөгдөж байна. Тухайлбал, төлөвлөж буй УЦС-ын далангаас нуурт үзүүлэх байгаль орчны нөлөөлөл, нийгэм-эдийн засгийн эрсдэл (IUS-Weiser & Ness, 2000) болон эдийн засгийн үр ашгийн (Баатар, 2002) талаар явуулсан судалгааны үр дүнгээр энэхүү төсөлд ихээхэн болгоомжтой хандахыг санал болгосон байна.

Тиймээс, эдгээр судалгааны гол дүгнэлтүүдийг толилуулахын хамт Дөргөний УЦС-ын талаар тус Хөтөлбөрийн Газраас баримталж буй байр сууриа илэрхийлж байна.

Мөн энд, тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчны талаар Монгол улсын баримталж буй бодлого, УЦС-ын талаар Дэлхийн Далангийн Комиссоос баримталж буй бодлого зэргийг товчлон танилцуулж байна.

### **1. Хар-Ус нуурын усны горим ба Дөргөний УЦС-ын төсөл хэрэгжсэнээр байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар явуулсан судалгааны үр дүн**

Германы “Вайсэр энд Нэсс” компаниас Монголын ШУА-ийн зарим эрдэмтэдтэй хамтран 2000 онд явуулсан судалгааны үр дүнгээс үзэхэд, Дөргөний УЦС-ын үндсэн хэсэг болох 18 м өндөр далан, мөн УЦС-ын ашиглалтаас хамааран Хар-Ус нуурын болон далангаас доошхи хэсгийн усны түвшний хэлбэлзэлд ихээхэн өөрчлөлт гарч болох ба энэ нь цэнгэг усны экологи болон мал сүрэг, орон нутгийн хүн ардын өвөлжилтийн байдалд сөргөөр нөлөөлнө гэж үзжээ. Чоно-харайх голын хавцалд далан барьснаар энэ хэсэг 14 м хүртэл гүн усанд автаж усны түвшин ихээхэн хэлбэлзэж, Хар-Ус нуурын зүүн хэсэг болох Далай нуурын усны түвшин бараг 1 м орчим нэмэгдэж, мөн Далай нуурын усны зах 100 м хүртэл тэлж болзошгүй гэжээ. Үүний улмаас нуурын эрэг орчмын ногоон бүс болон голын усны горим ихээхэн өөрчлөгдөж үлэмж хэмжээний малын бэлчээр устахад хүрч болзошгүй юм.

Улмаар, энэхүү судалгаагаар Дөргөний УЦС-ын далан барьснаар:

- Өвлийн сүүл, хаврын эхэн үед усны түвшин харьцангуй доогуур байдаг үзүүлэлттэй харьцуулахад Далай нуурын (Хар-Ус нуурын зүүн хэсэг) усны түвшин мөн үед 50-100 см-ээр нэмэгдэнэ. Улмаар, усны гадаргуу дээр хөвөгч арлууд нь усанд автаж дундажаар 100 см орчим гүн усанд ургаж байгаа зэгсэн шугуй нь усны гүн 170 см болоход дасан зохицох чадваргүй болж устах,
- Далан барьж УЦС-ыг ажиллуулах нөхцөлд нуурын ус, түүнчлэн далангаас дооших хэсэгт ихээхэн нөлөөлөх,
- Далан барьснаар урсгалын хурд саарч, одоогийн байдлаар өвөл ус нь хөлддөггүй Чоно-харайх голын ус хөлдөх зэрэг магадлал өндөр байгааг тэмдэглэжээ.

### **2. Баруун бүсийн эрчим хүчний хангамжийн өнөөгийн байдал, хэтийн төлөвийн талаар хийсэн нийгэм эдийн засгийн судалгаа**

Баруун бүсийн эрчим хүчний системийн эдийн засгийн үр ашгийн талаархи судалгааны (Б.Баатар, *Итгэл-Аудит ХХК, 2002*) үр дүнгээс үзэхэд:

- Одоо ашиглаж буй шугам сүлжээний ашиглалт болон цахилгааны төлбөр тооцооны менежментийг сайжруулбал, ОХУ-аас импортоор авч буй эрчим хүч нь хангалттай бөгөөд эрчим хүчний сүлжээнд холбогдсон бүх сумын хэрэгцээг хангах боломжтой байна гэж дүгнэжээ.
- Мөн Дөргөний УЦС-ын гаргах 1 кВт.цаг цахилгааны үнэ нь ОХУ-аас авч байгаа

цахилгааны үнээс өндөр байх болно гэж үзээд илүү үнэтэй цахилгаан үйлдвэрлэгч барьж ашиглалтанд оруулснаар хэрэглэгч, үйлдвэрлэгчийн хоорондын харилцаанд илүү их хүндрэл гарч болохыг тэмдэглэсэн байна.

- Мөн, төвлөрсөн сүлжээнээс 40 км-ээс холгүй зайд орших сумдын төвийг төвлөрсөн сүлжээнд өндөр хүчдэлийн шугамаар холбох нь техникийн хувьд боломжтой, эдийн засгийн хувьд үр ашигтай байна гэж үзсэн байна.

### **3. Тогтвортой хөгжлийн талаар Монгол Улсын баримталж буй бодлого**

НҮБ-ын 1992 оны “21-р зууны Хөтөлбөр”-ийн дагуу “Монгол Улсын 21-р зууны Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр” (MAP-21)-ийг Засгийн Газрын 1998 оны 5-р сарын 26-ний өдрийн 82-р тогтоолоор баталсан билээ. Энэхүү хөтөлбөрийн дагуу Монгол Улс тогтвортой хөгжлийн замыг сонгож хүн ардынхаа өнөөгийн болон ирээдүйн сайн сайхныг хангаж дэлхийн хүн амын амьжиргааны стандартад хүрэх зорилт тавьсан болно. Өнөөгийн хүн амын өсөн нэмэгдэж байгаа нөхцөлд нийгмийн болон экологийн харилцан шүтэлцээт орчныг бүрдүүлэх асуудал тогтвортой хөгжлийн талаар Монгол улсын баримталж буй гол чиглэлд орсон билээ. “Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр” нь эдийн засгийн тогтвортой өсөлт, нийгмийн тэгш эрх, байгалийн нөөц баялгийн зүй зохистой ашиглалт зэргийг хөгжлийн гол стратеги хэмээн үзсэн билээ. Мөн цөлжилт идэвхжих, ой болон усны нөөц хомсдох зэрэг байгаль орчны доройтол, бусад сөрөг өөрчлөлтүүдийн эсрэг үндэсний ба олон улсын байгууллагын хамтын хүчээр тэмцэхийг чухалчлан заасан болно.

### **4. Усны хязгаарлагдмал нөөцийг тогтвортой ашиглах талаар Дэлхийн Далангийн Комисс (World Commission on Dams)-ын баримталж буй бодлого**

УЦС-ын ашиглалт, түүний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар 1980-аад он хүртэл ихээхэн туршлага хуримтлагдаж, томоохон далангийн нийт өртөг ба төлөвлөгдсөн ажлууд нь хэрэгжээгүй тохиолдлуудын талаар илүү их мэдээлэл гарах болжээ. Маш олон тохиолдолд, УЦС-аас ашиг олохын тулд байж боломгүй, ихэвчлэн огт шаардлагагүй зардлуудыг, ялангуяа нийгмийн болон байгаль орчны чиглэлээр (хүн ардыг нүүлгэн шилжүүлэх, байгаль орчинд хохирол учруулах г.м.)

гаргасан байна. Эдүгээ УЦС-ын далангийн нөлөөлөлд дэлхийн бүх гол, мөрний 60% нь өртөж, 40-80 сая хүмүүсийг нүүлгэн шилжүүлж, голын ай ав болон экосистем нь эргэлт буцалтгүй өөрчлөгдөж, эдийн засгийн сөрөг үр дагаврууд удаа дараа гарах болсны улмаас 1990-ээд онд далангийн эсрэг хөдөлгөөн олон оронд эрчимтэй өрнөж эхэлжээ.

Энэхүү маргаантай асуудлыг шийдвэрлэхийн тулд, “Дэлхийн Далангийн Комисс” (ДДК) (World Commission on Dams) хэмээх олон улсын байгууллага байгуулагдаж, хязгаарлагдмал усны нөөцийг тогтвортой ашиглаж орон нутгийн иргэдийн эрх ашиг болон унаган төрхөөрөө байгаа гол мөрнийг хамгаалахад чиглэсэн бодлогын зарчим, стратегийн зэрэглэлийг дараах 5 үндсэн хэлбэрээр тодорхойлжээ. Үүнд:

- Тэгш эрхтэй байх
- Үр ашигтай байх
- Шийдвэр гаргахад хамтран оролцох
- Тогтвортой байх
- Тооцоотой байх

ДДК-ийн дүгнэснээр, урд өмнө нь шийдвэр гаргахдаа нийгэм, байгаль орчин, удирдлагын болон санал, зөрөлдөөнтэй асуудлыг хангалттай харгалзан үздэггүй байжээ. Үүнийг сайжруулахын тулд байгаль орчны нарийвчилсан үнэлгээг чанарын өндөр түвшинд явуулах нь нийгэм эдийн засгийн ба байгаль орчны аливаа сөрөг нөлөөлөл гарахаас урьдчилан сэргийлэх гол арга зам гэж үздэг.

Гол мөрөн, түүний ай сав болон нийт усны экосистем нь манай ертөнцийн биологийн хөдөлгүүр болдгийн хувьд урт удаан хугацааны туршид хүн ардын аж амьдралыг тэтгэдэг билээ. Гэтэл, далан барьж байгуулснаар орчны ландшафтад өөрчлөлт орж сөрөг нөлөөлөл үүсэх эрсдэл ихэсдэг байна. Голын ай савын хэмжээнд экосистемийг ойлгож, хамгаалж, улмаар нөхөн сэргээж байх нь энэхүү системийн доторхи бүх амьдралын оршин тогтноход, мөн хүн ардын тэгш эрхт хөгжил цэцэглэлтийн таатай нөхцлийг хангахад чухал үүрэгтэй. Тиймээс, гол мөрний ойр

орчмын газар нутгийг хөгжүүлэх боломжуудыг нарийвчлан үнэлж, улмаар шийдвэр гаргахдаа усны нөөц, голын ай савын нэгдмэл байдал, түүний эрүүл ахуйд сөрөг нөлөөлөл учруулахгүй байх талаар онцгой анхаарах шаардлагатай болж байна.

### Зөвлөмж

ДБХС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн Газар дээр дурьдсныг нэгтгэн, Дөргөний УЦС-ыг барьж байгуулснаар орчны экологи болон эдийн засагт гарч болохуйц сөрөг нөлөөллийг харгалзан дараах арга хэмжээнүүдийг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан төгс үнэлгээг нэн түрүүнд хийлгэх
- Төслийн эдийн засгийн үр ашгийг нарийвчлан тооцох
- Төсөлтэй холбогдол бүхий хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих
- Засгийн газар болон орон нутгийн ард иргэдийн хүсэл, сонирхолыг уялдуулах зэрэг болно.



## Дөргөний УЦС-ын талаар ДБХС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн Газраас баримталж буй байр суурь

### Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (ДБХС)-гийн Монгол дахь Хөтөлбөрийн Газар

Улаанбаатар 46  
Худалдааны гудамж 5  
Ус цаг уурын хүрээлэнгийн байр, 309 тоот  
Утас: +976 11 311 659  
Факс: +976 11 310 237  
И-мэйл: [wwfmon@magicnet.mn](mailto:wwfmon@magicnet.mn)  
Вэб хvвдас: <http://www.wwf.mn>

Улаанбаатар хот  
2003 оны 1-р сарын 15